



АВСТРАЛИЙН МАРГААН
ШИЙДВЭРЛЭХ НИЙГЭМЛЭГ
Шуудангийн хайрцаг A2468
Sydney South NSW 1235

Электрон шуудан: info@adra.net.au



ЭВ НЭДЭЛ, ИТГЭЛ, ЭВЛЭРҮҮЛЭН
ЗУУЧЛАХ ТӨВ
#1003, 13 floor, ICC tower, Sukhbaatar
District, Ulaanbaatar, Mongolia

Bvambasuren001@gmail.com
+976 99900797

ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН
САНАМЖ БИЧИГ

ЭНЭХҮҮ ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ
БИЧИГ (цаашид "Санамж бичиг" гэх)-ийг 2020 оны [...] сарын [...] -ний өдөр дараах
талуудын хооронд байгуулав: July 1st

АВСТРАЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ НИЙГЭМЛЭГ (ABN 75 535 099 840)
Ш.х А2468, SYDNEY SOUTH NSW 1235 ("ADRA"); болон

Монгол улсын Улаанбаатар хот дахь ЭВ НЭГДЭЛ, ИТГЭЛ, ЭВЛЭРҮҮЛЭН
ЗУУЧЛАХ ТӨВ ТББ #1003, 13 Floor, ICC tower, Sukhbaatar District, Ulaanbaatar,
Mongolia (цаашид "ЭНИЭЗТ" гэх)

ҮНДЭСЛЭЛ

А. Энэхүү Санамж бичигт тодорхойлсон зорилгод хүрэхтэй холбоотойгоор талууд
хамтран ажиллах сонирхолтой байна.

Б. Энэхүү Санамж бичиг нь талуудын хоорондын анхан шатны харилцаа болон тал
тус бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон болно.

В. Энэхүү Санамж бичиг нь аль нэг талдаа хуулийн хариуцлага хүлээлгэхийг
зориогүй бөгөөд зөвхөн тал бүрийн хүлээлтийг баримтжуулах зорилго агуулсан
болно.

С. Энэхүү Санамж бичгийн дагуу талууд бие биедаа шударгаар хандах ёстой.

1. ЗОРИЛГО БОЛОН ЗОРИЛТ

(a) Талууд хамтран ажиллах боломжийг судлах, мөн Монголын төсөл (цаашид
"Төсөл" гэх) хэмээн нэрлэгдэх төсөл дээр бодитойгоор хамтран ажиллахыг зорьж
буй болно.

(b) Төсөл дараах (the "Purpose"):

1. ЭНИЭЗТ нь АМШН-ийн харьяа байгууллага болох бөгөөд АМШН-ийн харьяа,
'АМШН-ийн гишүүн' зэрэг болон эдгээртэй ижил утга бүхий үг хэллэгийг тодорхой
хугацаанд өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг АМШН-ийн ерөнхий журам болон
засаглалын зарчимтай нийцэж буй тохиолд маркетингийн зорилгоор ашиглаж эрхтэй
юм.

2. ЭНИЭЗТ болон АМШН нар нь олон улсын маргаан шийдвэрлэх зарчмууд болон
АМШН-ийн Ерөнхий Дүрмийн шаардлагад нийцүүлэн өөрийн стандартыг бий болгох
эрх чөлөөг эдэлнэ.

2. ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

(a) Талууд энд дараах зүйлийг хүлээн зөвшөөрч байна:

(i) Санамж бичгийн нөхцөл нь талуудад хуулийг хариуцлаг хүлээлгэх
байдлаар хийгдээгүй болно;

(ii) Энэхүү Санамж бичгийн нөхцөл биелэгдэхээр байх;

- (iii) Энэхүү Санамж бичгийн нөхцөл талуудын хооронд хуулийн харилцаа үүсгэхээргүй байх;
- (iv) Энэхүү Санамж бичиг аль нэг талдаа ямар нэг эрх үүрэг, хариуцлага бий болгохгүй байх;
- (v) Энэхүү Санамж бичиг нь талуудын зорилгыг тодорхойлж, тэдгээрийн харилцан хамтын ажиллагааг дэмжихэд зориулагдсан болно;
- (vi) Энэхүү Санамж бичгийн болон түүнээс цааших хугацаанд хоёр талын хооронд байгуулж болох бусад гэрээ хэлэлцээрт уг Санамж бичиг ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно, Түүчлэн
- (vii) энэхүү санамж бичиг нь дээрх дэд зүйлд зааснаас үл хамааран энэхүү санамж бичигт гарын үсэг зурсан өдрөөр хүчинтэй болж, талуудын тус тусын зорилгыг нарийвчлан илэрхийлж байгаа болно.

3. САНАМЖ БИЧИГТ ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

- (a) Хоёр талын харилцан зөвшөөрснөөр энэхүү Санамж бичигт хэзээ ч өөрчлөлт оруулж болно. .
- (b) Энэхүү Санамж бичигт оруулсан өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд хоёр тал харилцан гарын үсгээ зурна.

4. ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

- (a) Энэхүү Санамж бичгийн албан бус мөн чанараас хамаарахгүйгээр талууд шударгаар ажиллах бөгөөд Зорилгоо биелүүлэх, уг Санамж бичгийн нөхцлийг хэрэгжүүлэхийн тулд бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллах болно.
- (b) Талууд энэхүү Санамж бичгийн нөхцлийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бүх ажлыг гүйцэтгэж, бүх баримт бичгийг бүрдүүлэхийг хүлээн зөвшөөрч байна.
- (c) Талууд харилцан хамтын ажиллагааг хөгжүүлэх, Зорилгодоо хүрэхийн тулд харилцан ойлголцол, сайн сэтгэлийн үндсэн дээр хамтран ажиллахаа тохиролцов.

5. ТӨСЛИЙН ХУГАЦАА, ОГНОО

- (a) Энэхүү Санамж бичгийн эхэлсэн огноог сүүлийн тал хамтын ажиллагаа эхлүүлсэн өдрөөр тооцно.
- (b) Энэхүү Санамж бичиг хоёр тал цуцлах буюу аль нэг тал гарах хүртэл хүчинтэй үйлчлэх болно.

(c) Аливаа тал энэхүү Санамж бичгээс гарах эсвэл уг бичгийг цуцлахыг хүсвэл нөгөө талдаа саналаа нэг сарын өмнө бичгэн хэлбэрээр хүргүүлэх ёстой.

(d) Аль нэг тал энэхүү Санамж бичгээс энэхүү заалтын дагуу гарахыг хүсвэл уг Санамж бичгээр нөгөө талын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага нь Санамж бичигт өөрөөр заагаагүй бол, хоёр талын хоёулангийнх нь хувьд дуусгавар болно.

6. САНАМЖ БИЧГИЙГ ЦУЦЛАХ БУЮУ УГ САНАМЖ БИЧГЭЭС ГАРАХ

(a) Энэхүү Санамж бичиг нь дээр дурдсан 5-р зүйлийн дагуу цуцлагдаж эсвэл аль нэг тал гарсан тохиолдолд:

- (i) Энэхүү Санамж бичгийн дагуу аль ч тал нөгөө талынхаа өмнө ямар нээг хариуцлага үүрэхгүй; бөгөөд;
- (ii) Дээр дурдсан дэд хэсгийг үл харгалзан, аль нэг тал нь энэхүү Санамж бичгээс өөр асуудлаар нөгөө талдаа гэрээ зөрчих, зүй бус үйлдэл болон хөрөнгийн зэрэг болон бусад асуудлаар хариуцлага хүлээлгэж болно.
- (iii) Нэг тал ("Эхний Тал") нь нөгөө тал ("Хоёр дахь Тал")-ынхаа тоног төхөөрөмж, материал, бичиг баримт, оюуны өмч, өгөгдөл болон бусад мэдээллийг ("Эд зүйлс") эзэмшиж байгаа бол Эхний Тал нь Хоёр дахь Талдаа уг Эд зүйлсийг тоо ёсоор эргүүлэн тушаах ёстой бөгөөд эсвэл Хоёр дахь талын зааварчилсны дагуу тэдгээр Эд зүйлсийг устгалд оруулна.

7. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ

(a) Энэхүү Санамж бичиг хуулийн зүйн хувьд албан бус мөн чанартай ч шаадлагатай бол хууль үйлчлэх болсон тохиолдолд хоёр тал харилцан буцалтгүйгээр ийнхүү тохиролцов:

- (i) Энэхүү Санамж бичиг нь Нью Саут Уэйлсийн гэрээгээр зохицуулагдах бөгөөд
- (ii) талууд зөвхөн Нью Саут Уэйлсийн шүүхэд харьяалагдах болно.

8. ХОРИГЛОЛТ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(a) Аливаа шүүхийн харьяалалт нутаг дэвсгарт хориглогдсон энэхүү Санамж бичгийн заалт болон заалтын хэрэгжилт нь шүүхийн бусад харьяалалд зөвхөн тухайн хориглолтынхоо хэмжээнд л үйлчилнэ.

(b) Энэхүү Санамж бичгийн аль ч шүүхийн харьяалалд хүчингүй, хууль бус, хэрэгжүүлэх боломжгүй заалт болон заалтын хэрэгжилт нь шүүхийн бусад харьяалалд уг заалтын болон бусад заалтын бусад шүүхийн харьяалал дахь хүчин төгөлдөр, хууль ёсны болон хэрэгжүүлэх байдалд нөлөөлөхгүй болно.

9. ЗАРДАЛ

Бичгээр урьдчилан тохиролцоогүй л бол Тал бүр энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх болон энэхүү Санамж бичгээр олгосон үүргээ биелүүлэхтэй холбогдон гарах өөрсдийн бүх зардлыг хариуцах болно.

10. ХАМТРАГЧ ТАЛУУД

Гарын үсэг зурсан хэдэн ч хамтрагч тал мөн нэг болон түүнээс дээш талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлж болно.

Хамтрагч тал уг санамжийг хэрэгжүүлсэн тохиолдолд жинхэнэ хэмээн тооцогдох бөгөөд хамтрагч нийм талууд бүгдээрээ нэг баримт бичигт захирагдах бөгөөд Санамж бичгийн огноо нь сүүлийн тал хамтрагч тал болсон өдөр байх болно.

ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАЛУУД:

ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН АВСТРАЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ НИЙГЭМЛЭГ:




Катерин Жонсон
Хамтарсан Ерөнхийлөгч




Эндрью Уонг
Хамтарсан Ерөнхийлөгч

ХЭРЭГЖҮҮЛСЭН ИТГЭЛ, ИТГЭЛ, ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТӨВ:



Ичинхорлоогийн
Төвийн дарга



Ичинхорлоогийн Лхагвадулам
Эрх зүйч